

“Там” гэдэг ойлголт хаанаас гарч ирсэн бэ?

Олон хүн “там” гэдэг ойлголтыг «Хуучин Гэрээ»-нд өгсөн Бүтээгч Эзэний илчлэлт гэж үздэг боловч тийм биш гэдгийг бид эхний нийтлэлээс олж харсан. Библид үхлийн тухай их мэдээлэл байгаа боловч там буюу “үхлийн дараа зовж тарчлах газар”-ын тухай ойлголт «Хуучин Гэрээ»-нд ч байхгүй, «Шинэ Гэрээ»-нд ч байхгүйг бид олж харсан. Тэгсэн ч гэсэн Христийн тухай авралын зар тараахад хүмүүсийг тамаас болгоомжлон, тамаас аврагдахын тулд Есүст итгэх ёстой гэж уриалах нь олонтаа.

Хэрэв тамын тухай түгээмэл энэ ойлголт Бүтээгч Эзэний Үг болох Библид байхгүй бол чухам хаанаас гарч ирсэн бэ?

Сонирхолтой нь, бусад шашин бүгд тамын тухай сургаал номлолтой. Энэ сургаал нь аргагүйн эрхээр “үхэшгүй сэтгэл”-ийн сургаалтай нь холбоотой. Эрүүл ухаантай хүний санаанд ормооргүй дэндүү аймаар олон янзын тамын дүрслэлийг шашинлаг хүмүүс гаргасан. Энд ганц тийм харгис хэрцгий төсөөлөл үзүүлсэн зургыг тавьлаа.



Энэ бол Библийн дагуух төсөөлөл биш ээ!



Там: эртний шашнаас үүсэлтэй ойлголт □ 2



Бүхий л муу муухай юм дүүрэн өчнөөн тийм зураг Улаанбаатар дахь Гандан, Чойжин Ламын сүм, Тэрэлжид буй Арьяабал сүм зэрэг шар шашны сүм хийдээс олж болно. Бүр аливаа аймшигт тамлалыг хөшөөгөөр үзүүлсэн

“зугаалах” цэцэрлэг хүрээлэн хүртэл Тайланд улсад байдаг (“[Thailand Hell Horror Park](#)”).

Энэ талаар анхааралдаа авах хамгийн чухал зүйл бол энэ: Тийм аймшгийн төсөөлөл Библийн хаанаас ч олдохгүй!

Дээрх зурагнаас жишээ авахад, хүмүүсийг тамд зовоох Эрлэгийн элч мэт чөтгөрийн тухай, эсвэл тамын тогоонд чанагдах тухай лав нэг ч үг олдохгүй. Есүсийн хэлснээр тодорхой нэгэн гал хүмүүст зориулж биш, харин Сатан болон түүний ёрын муу элч нарт зориулж бэлтгэгдсэн байна (Матай 25:41).

Харин хүн үхэхдээ хаашаа явах тал дээр Библи тов тодорхой хариу өгсөн байдаг. Үүнд: Хүн булшинд орж хэвтээд оршин байхаа больдог. «Номлогчийн үгс» 9-р бүлгээс та өөрөө уншаарай. Тэгвэл “там” гэсэн ойлголт хэрхэн Христитгэлд орсон бэ?




Там: эртний шашнаас үүсэлтэй ойлголт □ 3

Эртний шашин

Энэ ойлголт Христийн өмнөх үеийн өөр эх үүсвэрээс гарсныг олон түүхэн эх сурвалж мэдүүлнэ. Сенека, Полибий, Страбон, Платон, Плутарх, Тимей Локрус, Хрисипп, Ливи, Дионисиус Халикарнас, Аристотель зэрэг эртний грек ба ромын яруу найрагч, гүн ухаантан, төрийн зүтгэлтэн бүгд “там” гэсэн төсөөллийн гарал үүслийг адилхан тайлбарладаг. Тухайлбал:

1. Грек гүн ухаантан **Платон** (МЭӨ 425-348) философич Тимей Локрусын дараах үгийг тэмдэглэжээ. Үүнд: “Хүн нас барсныхаа дараа нэг бол шагнуулна, нэг бол шийтгүүлнэ гэж заадаг шашны сургаал нийгэмд зайлшгүй шаардлагатай. Заримдаа бие



махбодийг хорт эмээр эмчлэх шаардлагатай болдгийн адил үнэнээр ятгагдахгүй оюун ухааныг хуурамч ойлголтоор хазаарлахаас өөр аргагүй. Тийм хүмүүсийг хачирхалтай гаж тарчлалаас айх айдас төрүүлэх шаардлагатай. Тухайлбал: Үхэшгүй сэтгэл дараагийн төрөлд шилжих үед хулчгар эр байсан нь эмэгтэй хүний биед гутамшигтайгаар шахагдана, алуурчин байсан нь зэрлэг араатны биед хоригдоно, худалч хувирамтгай нь шувуу болно, залхуу мунхаг нь загас болж төрнө гэж заах ёстой.”



Там: эртний шашнаас үүсэлтэй ойлголт □4

Үхлийн дараах байдлын тухай сургаал зохиомол гэж хэлсэн Тимей Локрусын дээрх үгийг Платон бүрэн зөвшөөрдөг юм. Гэтэл бичиж үлдээсэн бусад үг нь зөрүүтэй, заримдаа яруу найрагчдын үлгэрийг үнэн юм шиг бичнэ, заримдаа огт худал бөгөөд хэтэрхий аймшигтай ойлголт өгдөг гээд үгүйсгэнэ. Заримдаа шашны эдгээр ойлголт муу хүмүүсийг ёс бус үйлдлээс болиулах учраас нийгмийн сайн сайханд хэрэгтэй гэдэг. Гэвч эдгээр домог иргэдийг айлган сүрдүүлж, цэргүүдийг хулчгар болгодог учраас хэрэггүй гэж дахин эсэргүүцдэг.

Тамын тухай онол сургаалыг Платон зарим тохиолдолд ашигтай, өөр тохиолдолд төвөгтэй зохиомол хэрэг гэж бичсэнээс харахад тус сургаалыг үнэн гэж хараагүй нь лавтай.



2. Газарзүйч **Страбон** (МЭӨ 63 - МЭ 23):
"Платон ба Энэтхэгийн шашны удирлагууд тамын ирээдүйн дуусаашгүй шийтгэлийн тухай үлгэр домог зохиожээ."

Страбон үргэлжлүүлэн: "Гэмт хэрэгтнүүдэд үхлийн дараа бурхдын оноох шийтгэл бий гэж заахаар олон түмнийг бузар мууг үйлдэхээс сэргийлнэ. Аймшиг төрүүлэх хэдэн үг, хэрцгий догшин хэдхэн төсөөлөл хүмүүсийн тархинд суулгаснаар гэмт хэрэг үйлдэхээс тэднийг болиулж, буян хийхэд хүргэж болох юм.



Учир нь, мунхаг ард олонтой гүн ухаанаар учирлан, тэднийг сүсэг бишрэл, ариун байдал, буянтай журамд хөтлөх нь бүтэхгүй юм. Энэ зорилгод мухар сүсэг, бурхдын тухай, үлгэр домог, гайхамшгийн тусламжаар хүрнэ... Эртний бүх шашны номлол ердөө л үлгэр домог юм. Эдгээр ойлголтыг хууль тогтоогчид зүггүй томоогүй, хүүхдэрхүү олныг айлган сүрдүүлэх мануухай шиг ашиглаж ирсэн" гэжээ.

3. Үхлийн дараах шийтгэлийн тухай аймшигт үлгэрээр хүмүүсийг буруу зүйл хийхээс сэргийлэхийг оролдсон гэж **Криссипп** (МЭӨ 281-208) мөн адил Платоныг буруутгадаг.

4. Түүхч **Полибий** (МЭӨ 2-р зуун): "Олон түмэн хэзээд хувирамтгай бөгөөд хууль бус шунал, үндэслэлгүй хүсэл тэмүүлэл, хүчирхийллээр дүүрэн байдаг тул хууль дүрэм сахиулахын тулд үл үзэгдэгч ертөнцөөс айх айдас ашиглахаас өөр арга зам байхгүй. Миний харснаар өвөг дээдэс маань бурхад болон тамын тухай эдгээр ойлголтыг олон нийтийн итгэл үнэмшилд оруулахдаа ухаалгаар ажилласан юм."





5. Ромын гүн ухаантан, яруу найрагч **Сенека** (МЭ 1-65) бичихдээ: "Тамыг аймшигтай болгодог түнэр харанхуй, шорон гяндан, галаар урсах гол мөрөн, шүүлтийн хар сэнтий зэрэг зүйлс бүгд үлгэр домог. Эдгээр үлгэрээр яруу найрагчид өөрсдийгөө зугаацуулж, харин ардыг дэмий айдсаар түгшүүлдэг юм."

6. Ромын эмч ба гүн ухаантан **Секст Эмпирикус** (МЭ 2-р зуун) эдгээрийг "тамын яруу найргийн үлгэр" гэж нэрлэсэн бол Ромын улс төрч, хуульч, гүн ухаантан, яруу найрагч **Цицерон** (МЭӨ 106-43) эдгээрийг "дэмий балай тэнэглэл, үлгэр домог юм" (inertiis ac fabulis) гэж хэлжээ.



Үгийг нь товч хураахад, "соёлгүй бүдүүлэг, мэдлэггүй мунхаг ардыг хянан тогтоох хамгийн үр дүнтэй арга зам бол айдас төрүүлэх явдал юм. Үхлийн дараа бурхад сайн хүмүүсийг шагнаж, муу хүмүүсийг тамлан шийтгэдэг (эсвэл хүсмээргүй дараагийн төрөлтөөр төрүүлдэг) гэсэн зохиомол онол сургаал нийгмийн сайн сайханд хэрэгтэй. Тамын тухай сургаал бол ардыг захирагчийн эрхшээлд байлгахад зайлшгүй хэрэгтэй зэвсэг юм" гэх мэтээр бичсэн байдаг.



Тамын тухай сургаалын гарал үүслийн талаарх асуултанд итгэлтэй хариулахаар хангалттай олон гэрчийн гэрчлэл бий. Эгэл ард түмнийг өөрийн эрхшээлдээ байлгах цорын ганц арга зам гэж үзсэн эрх мэдэлтнүүд тамыг өөрсдөө зохиожээ. Тэд өөрсдийн зохиосон домогтоо итгэдэггүй байсан нь ойлгомжтой.

Өнөөдөр ч ялгаагүй. Хэрэв өнөөгийн эрх мэдэлтнүүд өөрсдийнхөө дэвшүүлдэг үлгэр домогт үнэнээсээ итгэдэг байсан бол биеэ эрс өөрөөр авч явах байхсан. Зан авирыг нь ажиглаваас эдгээр улс төрч, бизнесмен, ба ялангуяа шашин ба сүмийн удирдагчид өөрсдөө үхлийн дараах шийтгэл байдагт өчүүхэн ч итгэдэггүй шинжтэй.

Айдас бол хайранд харш

Өнөөдөр Христитгэлийн олон удирдагч итгэгчдийг гэм нүгэл хийхээс сэргийлэхэд тамын шийтгэлээс айх айдас хэрэгтэй гэж зүтгэдэг. Тэд эртний эрх баригч нартай адилхан бодлоготой нь харагдаж байна.



Гэтэл Бүтээгч Эзэн Өөрөө итгэгчдийг бүү хэл, хүн төрөлхтөнийг хэзээ ч тамын айдсаар айлгаагүй. Есүс биднийг домгийн тамаас биш, харин бодитой гэм нүгэл ба үхлээс аврахаар хүн болж төрсөн.



Там: эртний шашнаас үүсэлтэй ойлголт □ 8

Есүс биднийг ертөнцийг бүтээгч Аавтайгаа эвлэрүүлж хүүхдүүд нь болгохоор ирсэн. Түүгээр дамжин итгэгч бид “дахин айдаст хүргэх боолчлолын сүнсийг хүлээн аваагүй, харин үрчлэлийн Сүнсийг авсан билээ. Түүгээр бид [Бүтээгч Эзэнээ] “Аав аа! Эцэг минь!” гэж дууддаг. Биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг Сүнс Өөрөө бидний сүнстэй хамт гэрчилдэг” (Ром 8:15-16).

Түүний бидэнд өгсөн тэр Сүнс бол “айдсын сүнс биш, харин хүч, хайр, биеэ захирах сүнс” билээ (2 Тимот 1:7)! Учир нь, Бүтээгч Эзэн Өөрөө хайр бөгөөд Түүний хайраас хэн ч, юу ч биднийг салгаж чадахгүйд бид бат итгэлтэй байж болно (Ром 8:38-39)!



Иймд Аавын маань Үгэнд “бүү ай” гэсэн зоригжуулах үгс ахин дахин гардаг. “Хайр дотор айдас үгүй. Харин төгс хайр нь айдсыг хөөн зайлуулна... Айдаг нэгэн нь хайр дотор төгс болгогдоогүй байна. Эхлээд Тэр биднийг хайрласан тул бид хайрладаг” (1 Иохан 4:8,18-19). □

Тэгэхээр тамын тухай сургаал Христийн сүмд хэрхэн орсон бэ? Энэ талаар дараагийн нийтлэлдээ авч үзнэ.



Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон. Орчуулга тодруулаагүй тохиолдолд АБ-с авсан гэсэн үг.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон.

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org

---Thayer, T. B. (1855). The Origin and History of the Doctrine of Endless Punishment. <https://www.tentmaker.org/books/OriginandHistory.html>